

ТАНИЛЦУУЛГА

Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журмын тухай

Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр шинэчлэн баталсан Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэгт “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журмыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн хамтран батлахаар заасан бөгөөд мөн хуулийн 80 дугаар зүйлийн 80.6 дахь хэсэгт “Сэтгэцэд учирсан хор уршгийг үнэлэх, хор уршгийг мөнгөн хэлбэрээр арилгуулахтай холбоотой Шүүх шинжилгээний тухай хууль болон дагалдах бусад хуулийн зохицуулалтыг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх”-өөр зохицуулсан.

Үүний дагуу “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам”-ын төсөл боловсруулсан.

Монгол Улсад гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг Иргэний хууль, Эрүүгийн хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулиар бүрэн тооцож байгаа ч эдийн бус буюу сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх иргэний нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэрлэх нь аль ч талаасаа хангалтгүй учир дутагдалтай байна. Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг шүүхээр эцэслэн барагдуулдаг хууль эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг хамгаалахад чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлд гэмт хэргийн хохирол, хор уршгийн ялгааг нарийвчлан тодорхойлсон байдаг. Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус сэтгэл санааны хохирол, гэм хорыг нэхэмжлэх талаар хуульд тодорхой заасан боловч сэтгэл санааны хохирлыг тооцож арилгахтай холбоотой зохицуулалт байхгүй гэсэн үндэслэлээр хэргийг шийдвэрлэхгүй орхигдуулдаг юм. Иймд иргэнийхээ зөрчигдсэн эрхийг сэргээх, нөхөн төлөх эрх зүйн орчин, тогтолцоо механизмыг бүрдүүлэх зайлшгүй шаардлага үүссэн.

Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг Иргэний хууль, Эрүүгийн хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулиар бүрэн тооцож байгаа ч эдийн бус буюу сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх иргэний нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэрлэх нь аль ч талаасаа хангалтгүй учир дутагдалтай байсан учраас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлд Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох үнэлгээ гэсэн эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан.

Шүүх шинжилгээний хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д заасан Эрүүгийн хуулийн 14 бүлгийн 85 гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох, дүгнэлт гаргах журмыг Шүүх шинжилгээний тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай, Иргэний хууль болон холбогдох журмуудтай уялдуулан боловсрууллаа.